

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 2-3

1.Горимын санал 2-3

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 17 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Наранбаатар, Ж.Эрдэнэбат;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Энх-Амгалан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 1
Бүгд: 9

88.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 02 минут үргэлжилж, 17 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 82.3 хувийн ирцтэйгээр 09 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
09 цаг 17 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужин ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайваны Бат-Амгалан ирсэн, Баагаагийн Баттөмөр ирсэн, Сүхбаатарын Батболд өвчтэй, Дашдондогийн Ганбат ирээгүй байна, Борхүүгийн Дэлгэрсайхан ирээгүй байна, Нанзадын Наранбаатар орон нутагт томилолттой байна, Салдангийн Одонтуяа ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн ирсэн байна, Дамдины Цогтбаатар чөлөөтэй байна. Нямаагийн Энхболд ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат орон нутгийн томилолттой байна.

Гишүүдийн ирцийг танилцуулж танилцуулж дууслаа. Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын

Ерөнхийлөгчөөс 2024 оны 4 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн асуудлыг зөвшилцөх.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн алга байна. Ганибалын Амартүвшин гишүүн саналаа хэлье. Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Өнөөдөр байнгын хороогоор энэ Элчин сайд нарыг томилох асуудал бид нар хэлэлцэнэ. Тэгээд ер нь энэ улс орнуудын харилцаатай холбоотой, тэр дотроо манай урд хөрштэй холбоотой асуудал яригдахад би энэ хуралдааныг хаалттай горимоор явуулах горимын санал гаргаж байна.

Энэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-д заасны дагуу хаалттай горимоор хэлэлцье гэж санал гаргаж байна.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д горимын саналыг Их Хурлын гишүүн гаргана. Ганибалын Амартүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 9 гишүүн санал хураалтад оролцсоноос 8 гишүүн дэмжиж, 88.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Амартүвшин гишүүний горимын санал дэмжигдсэн учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя. Ажлын хэсэг хаалттай горимд шилжүүлээдэх.

09.19 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР